



БУЛГАН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

БУЛГАН АЙМГИЙН НИЙГЭМ ЭДДИЙН ЗАСГИЙН байдал

Monthly bulletin of **STATISTICS**

2020/9

www.bulgan.nso.mn



СТАТИСТИК МЭДЭЭЛЛИЙГ ХЭРХЭН АВАХ ВЭ?

www.1212.mn

СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН
НЭГДСЭН САН

www.nso.mn сайтын
Хэрэглэгчийн бүртгэлд
бүртгүүлснээр цахим
хаягаар тогтмол
авч болно.

Monstat ezStat
аппликейшн

Google play
App Store

1900-1212
Лавлах утас

@statistic_mn

Статистик
мэдээлэл

Үндэсний Статистикийн
Хорооны
НОМЫН САН

Онлайн лавлах
мессенжер
8:30-17:30

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ

ХҮНД СУРТАЛ
АВИЛГА

ҮГҮЙ НЭЭЛТТЭЙ
ХҮРГЭНЭ

ГАРЧИГ

Аргачлал тайлбар	4
Товч танилцуулга	8
I.1 Хүн ам	17
I.2 Хөдөлмөр	18
I.3 Нийгмийн халамж	19
I.3 Нийгмийн даатгал	20
I.4 Эрүүл мэнд	20
I.5 Гэмт хэрэг	21
II.2 Худалдан авах ажиллагаа	23
II.3 Үнэ	28
II.4 Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнэ	30
II.5 Малын үнэ	32
II.6 Аж үйлдвэр	33
II.7 Мал аж ахуй	34
II.8 Мал эмнэлгийн үйлчилгээ	38
II.10 Газар тариалан	39

Аргачлалын тайлбар

Хөдөлмөр

Бүртгэлтэй ажилгүй иргэдэд Монгол Улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхлэгдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхитэй хайж байгаа хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, хөдөлмөрийн төв бирж, хөдөлмөрийн хувийн биржид бүртгүүлсэн ажилгүй иргэдийг хамруулна.

Нийгмийн даатгал, халамж

Нийгмийн даатгал нь иргэн болон төр, аж ахуйн нэгж байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын сан бүрдүүлэх, даатгуулах, өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа алдах, өвчлөх, ажилгүй болоход өөрт нь, тэрчлэн даатгуулагч нас барахад түүний асрамжид байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр өгөх агуулга бүхий нийгэм эдийн засгийн арга хэмжээ юм. Тэтгэврийн, тэтгэмжийн, эрүүл мэндийн, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалан өвчний, ажилгүйдлийн даатгал гэсэн төрлөөс нийгмийн даатгал бүрдэнэ. Нийгмийн даатгалын сан нь ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах болон нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдэнэ. Нийгмийн даатгалын тухай хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд нийгмийн даатгалын шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг даатгуулагчаар тооцно. Тэтгэвэр нь даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь, хөгжлийн бэрхшээлтэй болоход хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, нас барахад нь түүний гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүд (хүүхэд 16 нас, сургуульд суралцаж байгаа бол 19 нас хүртэл)-ийн нийгмийн баталгааг хангах зорилгоор

нийгмийн даатгалын сангаас олгох мөнгөн хөрөнгө байна.

Тэтгэмж нь хөдөлмөрийн чадвараа түр алдах, жирэмслэх, амаржих, нас барах тохиолдолд даатгуулагчид нийгмийн даатгалын сангаас нэг удаа олгох мөнгөн хөрөнгө байна. Нийгмийн халамжийн дэмжлэг тусалцаа шаардлагатай хүнд хуульд заасан тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмж олгох, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн болон төрөлжсөн асрамжийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг нийгмийн халамж гэнэ

Эрүүл мэнд

Жирэмслэлтийн хугацаанаас хамаарахгүйгээр ердийн төрөлтөөр эсвэл мэс ажилбараар ургийг умайнаас гарган авсны дараа нярай амьсгалж байсан эсвэл амьдын бусад ямар нэгэн шинж тэмдэг, өөрөөр хэлбэл, зүрхний цохилт, хүйний судасны лугшилт, булчингийн тодорхой хөдөлгөөн илэрч байвал хүй эсвэл эхэсийг салгасан эсэхийг харгалзахгүйгээр амьд төрөлтөд тооцно.

Амьд төрсөн 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг тодорхойлохдоо тухайн хугацаанд 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулна.

Амьд төрсөн 1000 хүүхдэд ногдох хүүхдийн эндэгдлийг тооцохдоо тухайн хугацаанд 5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд хуваана. Эндсэн эхийн тоонд жирэмсний хугацаанд болон төрөх үедээ эсвэл төрснөөс хойш 42 хоногийн дотор жирэмслэлтийн байрлал, үргэлжилсэн хугацаанаас үл хамааран жирэмслэлт, төрөлт болон түүнийг удирдахтай холбоо бүхий шалтгаанаар эндсэн эхийг хамааруулна.

Халдварт өвчний өвчлөлийн 10000 хүнд ногдох түвшинг тооцохдоо тайлант хугацаанд амбулаторийн үзлэгээр шинээр бүртгэгдсэн нийт халдварт өвчний тохиодлын тоог тухайн хугацааны хүн амын тоонд харьцуулна.

Аюулт үзэгдэл, осол

Гамшиг гэж аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол, алан хядах ажиллагаа, дэлбэрэлтийн улмаас олон хүний эрүүл мэнд, амь нас хохирох, мал амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд улс, орон нутгийн дотоод нөөц боломжоос давсан хохирол учрахыг хэлнэ.

Аюулт үзэгдэл гэж хүчтэй цасан болон шроон шуурга, ган, зуд, үер, газар хөдлөлт, цөлжилт болох, гал түймэр, хүн, мал, амьтны болон ургамлын гоц халдварт өвчин гарах, хортон мэрэгчид тархах зэргийг хамруулан ойлгоно. Техникийн холбогдолтой осол гэж үйлдвэрлэл, технологийн горим зөрчигдсөнөөс тоног төхөөрөмж, барилга, байгууламж, шугам, сүлжээ эвдрэх, тээврийн хэрэгсэл осолдох, сүйрэх, цацраг идэвхт болон химийн хорт бодис алдагдах зэргийг хамруулан ойлгоно.

Гэмт хэрэг

Эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан, нийгэмд аюултай, гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэг гэнэ. Гэмт хэргийн нийгмийн шинж чанар, аюулын хэр хэмжээ, оногдуулж болох ялын хүнд хөнгөнийг харгалзан гэмт хэргийг хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд гэж ангилна. Гэмт хэргийн тоог Монгол Улсын Эрүүгийн хуульд заасны дагуу гэмт хэргийн төрлөөр нэгтгэн гаргаж байна. Тухайлбал:

- Хүний ам бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг
- Хүүхэд гэр бүл, нийгмийн эсрэг гэмт хэрэг
- Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг
- Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг
- Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг
- Хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг
- Тээврийн хэрэгслийн хөдөлгөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг
- Шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэрэг
- Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг
- Бусад гэмт хэрэг

18 ба түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэргийн тоог тодорхойлохдоо нийт бүртгэгдсэн гэмт хэргийн

тоог 18 ба түүнээс дээш насны хүн амын дундаж тоонд харьцуулна.

Дор дурьдсан этгээдэд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч эрүүгийн хэрэг үүсгэж, үндэслэл бүхий тогтоол гаргасан бол сэжигтнээр тооцно. Үүнд:

-Уг этгээдийг гэмт хэрэг үйлдэж байх үед буюу үйлдэл дор нь барьсан

-Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг хохирогч буюу харсан хүн шууд заасан

-Уг этгээдийн бие, хувцас, эд зүйл, орон байранд гэмт хэргийн ул мөр тодорхой илэрч олдсон

-Уг этгээд хэргээ илчлэн ирсэн

-Гэмт хэрэгт сэрдэгдэх үндэслэл бүхий бусад баримт байгаа бол

Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч тогтоол үйлдэж, ял сонсгосон этгээдийг яллагдагчаар тооцно.

Төрийн санхүү

Орон нутгийн төсвийн суурь орлого гэж тухайн шатны төсөвт орох татварыг доод хувь хэмжээгээр тооцсон орлого болон татварын бус орлогын нийлбэрийг хэлнэ. Орон нутгийн суурь зарлага гэж сум, аймаг, нийслэлийн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй холбогдох урсгал болон хөрөнгийн зарлага, нийгмийн асрамж, халамжийн үйлчилгээ, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлыг хэлнэ.

Төсвийн тэнцэл гэж тухайн төсвийн жил, улирлын нийт орлого, зарлагын зөрүүг хэлнэ. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас батлан аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга бүрдүүлж зарцуулах төсөв нь орон нутгийн төсөв байна.

Татварын орлогод орлогын албан татвар, нийгмийн даатгалын шимтгэл, хураамж, өмчийн татвар, дотоодын бараа, үйлчилгээний татвар, гадаад худалдааны татварын орлого болон бусад татвар орно.

Төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг, хүү, торгуулийн орлого,

түрээсийн орлого, төсөвт газрын өөрийн орлого болон татварын бус бусад орлогоос татварын бус орлого бүрдэнэ.

Төсвийн зарлагыг урсгал зардал, хөрөнгийн зардал, цэвэр зээл гэж ангилна. Бараа, үйлчилгээний зардал, зээлийн үйлчилгээний төлбөр, татаас ба урсгал шилжүүлгээс урсгал зардал бүрдэнэ.

Үнэ

Хэрэглээний үнийн индекс (ХҮИ) нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна. ХҮИ-ийн тооцоонд хэрэглээний сагс, хэрэглээний жин гэсэн хоёр үзүүлэлтийг ашиглана. Хэрэглээний сагс нь дундаж зарлагатай өрхийн хэрэглээг төлөөлөх чадвартай, хэрэглээний үнийн индекс тооцох зорилгоор бүрдүүлсэн хүн амын өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлтийг тооцоход бараа, үйлчилгээний тоо хэмжээ, төрөл, чанар зэргийг тогтмолоор авч үздэг. Хэрэглээний бараа үйлчилгээний жин гэж өрхийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нийт зардалд тухайн бараа, үйлчилгээний зардлын эзлэх хувийн жин юм. ХҮИ-ийн тооцоонд Ласпейресийн үнийн индексийн томъёог ашиглаж болно.

$$I_p^L = \frac{\sum_{i=1}^t p_{it} * q_{io}}{\sum_{i=1}^o p_{io} * q_{io}}$$

I_p^L - t тайлант үеийн Ласпейресийн үнийн индекс

t - тайлан үе

o - суурь үе

p_{it} - 'i' барааны тайлант үеийн үнэ,

p_{io} - 'i' барааны суурь үеийн үнэ,

q_{io} - 'i' барааны суурь үеийн худалдан авсан тоо, хэмжээ,

\sum - нийлбэрийн тэмдэг

Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл нь аж ахуйн нэгжүүдийн тайлант хугацаанд зах зээлд болон өөрийн эцсийн хэрэглээнд зориулж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс бүрдэнэ.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн нь аж ахуйн нэгжүүдийн тайлант хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

Аж ахуйн нэгжүүдийг эдийн засгийн үйл ажиллагаагаар нь ангилахдаа НҮБаас гишүүн орнууддаа мөрдөхийг зөвлөмж болгосон эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны олон улсын стандарт ангилалд үндэслэсэн үндэсний ангиллыг мөрдөж байна.

Ерөнхий тэмдэглэл

I. Саруудыг ром тоогоор тэмдэглэв (I, II, III, IV, V... гэх мэт)

Тухайн сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдэх дүнг харуулахдаа I-IV, I-X зэргээр илэрхийлэв.

II. Дараах тэмдэглэлийг ашиглав:

... мэдээлэл байхгүй

0.0 маш бага тоо

- гүйцэтгэл байхгүй

III. Орон дэвшүүлэлтээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас бага зэрэг зөрүүтэй байж болно.

I. Нийгмийн үзүүлэлт

Зураг I.2.1




I.1 Хүн ам

2020 оны 9-р сарын байдлаар иргэний бүртгэлд шинээр төрсөн 962 хүүхэд, нас барсан 350 хүний бүртгэлийг бүртгэсэн нь өмнөх оны мөн үеийнхээс шинэ төрсөн хүүхэд 284 буюу 9.5 хувиар, нас баралт 29 буюу 8.2 хувиар тус тус өсчээ.

Зураг I.1.1

Бүртгэгдсэн төрөлт, нас баралт



Хөдөлмөрийн хэлтэст шинээр бүртгүүлсэн, ажилд зуучлагдан орсон иргэд



Аймгийн хэмжээнд бүртгэлтэй ажилгүй иргэдийн 10.9 хувийг 15-24 насны, 37.3 хувийг 25-34 насны, 25.8 хувийг 35-44 насны, 19.7 хувийг 45-54 насны, 4.9 хувийг 55-59 насны, 1.9 хувийг 60-аас дээш, 1.4 хувийг хөгжшлийн бэрхшээлтэй иргэд эзэлж байна.

Зураг I.2.2

Бүртгэлтэй ажилгүй иргэд боловсролын түвшингээр



I.2 Бүртгэлтэй, ажилгүй иргэн

Аймгийн хөдөлмөрийн хэлтэст бүртгэлтэй ажилгүй иргэн 1140 болсны 561 нь эмэгтэй байна. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 17.9 хувийг бакалаврын болон дипломын боловсролтой, 3.5 хувийг тусгай мэргэжлийн дунд, 4.8 хувийг техникийн болон мэргэжлийн, 57.7 хувийг бүрэн дунд боловсролтой, 11.4 хувийг суурь боловсролтой, 3.3 хувийг бага боловсролтой, 0.9 хувийг боловсролгүй иргэд эзэлж байна.



I.3. Нийгмийн даатгал, халамж

Нийгмийн даатгал

Нийгмийн даатгалын сангийн орлого 10601.2 сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс 1423.8 сая төгрөг буюу 15.5 хувиар өсч, зарлага 36380.8 сая төг болж өмнөх оны мөн үеэс 6009.1 сая төг буюу 19.8 хувиар өссөн байна.

Тэтгэврийн даатгалын сангийн орлого өмнөх оны мөн үеэс 1631.3(21.8%) сая төгрөгөөр өсч, ҮОМШӨ-ний даатгалын сангийн орлого 184.7(27,2%) сая төгрөгөөр буурч, тэтгэмжийн даатгалын сангийн орлого өмнөх оны мөн үеэс 5.2(0,6%) сая төгрөгөөр буурсан ажилгүйдлийн даатгалын сангийн орлого 17,8(10%) сая төгрөгөөр буурсан байна.

Нийгмийн даатгалын сангийн зарлага 36380,8 сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс тэтгэмжийн даатгалын сангийн зарлага 134,4(13%) сая төгрөгөөр, ҮОМШӨ-ний даатгалын сангийн зарлага

39.5(7.6%) сая төгрөгөөр буурч, ажилгүйдлийн даатгалын сангийн зарлага 158.1(82.7%) сая төгрөгөөр өссөн байна. Харин тэтгэврийн даатгалын сангийн зарлага 5756.1(20.1%) сая төгрөгөөр, төгрөгөөр өссөн байна.

Нийгмийн халамж

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын мэдээллээр нийгмийн халамжийн сангаас 2020 9-р сарын байдлаар 7497 хүн 1065.9 сая төгрөгийн нийгмийн халамжийн тэтгвэр, тэтгэмж олгосон нь өмнөх оны мөн үеийнхээс 2241.5 сая.төг буюу 67.8 хувиар буурч, халамжийн тэтгэвэрт 1171 хүн хамрагдаж 2170.8 сая.төг олгосон нь өмнөх оны мөн үеийнхээс 688.3 сая.төг буюу 46.4 хувиар буурсан байна.

Нийгмийн халамжийн үйлчилгээ болон хөнгөлөлтөд 2695.3 сая.төг олгосон нь өмнөх оны мөн үеийнхээс 5170.8 сая.төг буюу 65.7 хувиар буурсан байна. Нийгмийн халамжийн үйлчилгээ болон хөнгөлөлтөд 2071 хүн хамрагдсаны 16.1 хувь ахмад настан, 3.0 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд, 80.9 хувь хүнс тэжээл хөтөлбөр хамрагдсан байна.




I.4 Эрүүл мэнд

Аймгийн хэмжээнд 2020 оны 9-р сарын байдлаар 582 эх амаржиж, амьд төрсөн хүүхдийн тоо 581 болж, өмнөх оны мөн үеийнхээс амаржсан эх 12 буюу 2.1 хувиар өсч, амьд төрсөн хүүхдийн тоо ижил байна.

Зураг I.4.1


Амаржсан эх, амьд төрсөн хүүхэд



2020 оны 9-р сарын байдлаар нялхасын эндэгдэл 10 гарсан байна.

Зураг I.4.2

Эндсэн хүүхэд, оноор



Халдварт өвчнөөр өвчлөгсөд 426 болж, өмнөх оны мөн үеийнхээс 112 тохиолдол буюу 26.3 хувиар өссөн байна. Нийт халдварт өвчнөөр өвчлөгсдийн 95 буюу 22.3 хувь нь амьсгалын

замын халдварт өвчин, 260 буюу 61.0 хувь нь бэлэгсийн замын халдварт өвчнөөр өвчилсөн байна.

Зураг I.4.3



- Хүчиндэх гэмт хэрэг 14 бүртгэгдэж 3 хэргээс буюу 21.5 хувиар
- Хууль бусаар мод бэлтгэх гэмт хэрэг 27 бүртгэгдэн 9 хэргээр буюу 33.4 хувиар
- Тээврийн хэгэслийн хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журам зөрчих гэмт хэрэг 24 бүртгэгдэж 3 хэргээр буюу 12.5 хувиар өссөн.
- Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 80 бүртгэгдэж 2 хэргээр буюу 2.5 хувиар
- Хулгайлах гэмт хэрэг 43 бүртгэгдэж 34 хэргээр буюу 44.2 хувиар
- Мал хулгайлах гэмт хэрэг 52 бүртгэгдэж 37 хэргээр буюу 41.6 хувиар
- Залилах гэмт хэрэг 10 бүртгэгдэж 9 хэргээр буюу 47.3 хувиар
- Дээрэмдэх гэмт хэрэг 1 бүртгэгдэж 2 хэргээр буюу 66.7 хувиар
- Хөрөнгө завших гэмт хэрэг 6 бүртгэгдэж 1 хэргээр буюу 14.3 буурсан байна.




I.5 Гэмт хэрэг

Аймгийн хэмжээнд 378 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 11 хэргээр буюу 2.9 хувиар өссөн байна.

Яллагдагчаар татагдвал зохих этгээд нь тогтоогдоогүй хэрэг 228 бүртгэгдсэн 102 хэргийг илрүүлж өнгөрсөн оны мөн үеэс 70 хэргээр буюу 40.7 хувиар буурсан байна. Илрүүлэлтийн хувь 44.7 хувьтай байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 9.4 хувиар өссөн байна.

Зураг I.5.1



Хэргийн өнгөөр нь авч үзвэл:

Гэмт хэргийн улмаас учирсан хохирол

Гэмт хэргийн улмаас нийт иргэд, аж ахуй нэгж байгууллагад 1419.1 сая төгрөгний хохирол учирснаас иргэдэд 785.8 сая төгрөгний хохирол учирсан байна. Үүнээс бүртгэлд мөрдөн байцаалтын шатанд 748.3 сая төгрөг буюу 52.7 хувийн хохирлыг нөхөн төлүүлж ажилласан байна.

Зураг I.5.2



Гэмт хэргийн улмаас учирсан хохирол /сая.төг/

Гэмт хэргийн улмаас 12 хүн нас барсан ба өнгөрсөн оны мөн үеийнхээс 52.0 хувиар буурсан байна. Гэмт хэргийн улмаас 97 хүн гэмтсэн нь хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн улмаас 80, хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн улмаас 17 хүнбайгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад ижил түвшинд байна.

Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 64 бүртгэгдэж 11 хэргээр буюу 17.2 хувиар өссөн.

Нийт 21 хэргийг бүлгээр үйлдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 8 хэргээр буюу 27.6 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

199 гэмт хэрэгт 199 хүн холбогдсон нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 20 хүнээр буюу 9.2 хувиар буурсан байна.

327 хүнийг баривчилж, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодож эрхээ хасуулж, торгуулсан 330 иргэн байна.



II. Эдийн засгийн үзүүлэлт

II.1 Аймгийн төсөв


Аймгийн төсвийн нийт орлого 2020 оны 9-р сарын байдлаар 50559.0 сая төгрөг, зарлага 43634.5 сая төгрөг болж, аймгийн төсвийн нийт тэнцэл 6924.5 сая төгрөгний эерэг гарлаа.

Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт орлого ба тусламжийн дүн 7.4 тэрбум төгрөг буюу 17.3 хувиар, урсгал орлого 1.6 тэрбум төгрөгөөр буюу 8.8 хувиар тус тус өссөн байна.

Нийт орлогоос аймгийн төсвийн орлого 21.9 тэрбум төгрөг буюу 102.4 хувийн, сумдын төсвийн орлого 28.6 тэрбум төгрөг буюу 99.8 хувийн гүйцэтгэлтэй байна. Урсгал орлогын гүйцэтгэл 19.3 тэрбум төгрөг буюу 110.5 хувь байна.

Зураг I.5.3

Гэмт хэргийн улмаас гэмтсэн, нас барсан иргэн




Захиргааны зөрчлийн талаар:

22150 зөрчилд 870.4 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авсан байна. Гудамж талбайд хэвийн бус явж орон гэртээ агсан согтуу тавьсны улмаас 646 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеийхээс 99 хүнээр буюу 15.4 хувиар өссөн байна. Зөрчлийн улмаас нийт

Зураг II.1.1


Аймгийн төсвийн орлого, зарлага, сая.төг



Төсвийн нийт зарлага 43634.4 сая төгрөг буюу 82.9 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс орон нутгийн төсвийн байгууллагуудын зардал 15471.1 сая төгрөг буюу 74.9 хувь, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын зардал 28163.3 сая төгрөг буюу 88.0 хувь байна.

Зураг II.1.2

Аймгийн төсвийн өр, авлага, сүүлийн сараар



Нийт өр 239.5 сая, нийт авлага 34.3 сая төгрөг байна. Сайдын багцаар авч үзвэл Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын байгууллагууд 105.9 сая, орон нутгийн байгууллагууд 35.4 сая, Эрүүл мэндийн сайдын байгууллагууд 98.2 сая төгрөгийн өртэй байна.

II.2 Худалдан авах ажиллагаа

2020 оны 3-р улирлын байдлаар орон нутгийн төсвөөс 2 төсөл арга хэмжээ буюу 79 сая.төг, орон нутгийн хөгжлийн сангаас 7 төсөл арга хэмжээ буюу 685.2 сая.төгрөг, байгаль хамгаалах сангаас 39 төсөл арга хэмжээ буюу 4352.7 сая.төг, улсын төсвийн хөрөнгө оруулалтын сангаас 20 төсөл арга хэмжээ буюу 8483.4 сая.төгрөг, нийт 69 төсөл арга хэмжээ буюу 14100.3 сая төгрөгийн төсөл арга хэмжээ зохион байгуулахаар батлагдсан байна. Батлагдсан төсөл арга хэмжээнээс нийт 68 төсөл буюу 11839.4 сая төгрөгийн төсөл арга хэмжээ гэрээ байгуулсан байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулвал нийт төсөл арга хэмжээ 32 хувиар, нийт батлагдсан төсөв 31 хувиар тус тус буурсан байна.

2020 оны 3-р улирлын байдлаар аймгийн хэмжээнд газар өмчлөхөөр 65 иргэн хүсэлтээ гаргасаны 15 иргэн буюу 23.1 хувь нь одоо эзэмшиж, ашиглаж байгаа хашааныхаа газрыг өмчилж авах, 50 иргэн буюу 76.9 хувь нь шинээр газар өмчилж авах хүсэлт гаргасан байна. Хүсэлт гаргасан нийт иргэдийн

хүсэлтийн 40 хувь шийдвэрлэж, 3.86 га газрыг өмчлүүлсэн байна. Иргэдийн өмчлөлд шилжсэн газрын 3.75 га буюу 97.2 хувь нь одоогийн эзэмшиж байсан газар нь 0.11 га буюу 2.8 хувь шинээр олгогдсон газар байна.




II.3 Үнэ

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс аймгийн хэмжээнд 2020 оны 9-р сарын байдлаар өмнөх оны мөн үеийнхээс 1.8 хувиар, оны эхнээс 0.9 хувиар өсч, өмнөх сарынхаас 0.2 хувиар өссөн байна.

Зураг II.3.1

Хэрэглээний бараа үйлчилгээний үнийн индекс, хувь, 2020 IX сар, (өмнөх сар =100%)



Хүснэгт II.3.1

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс, хувиар,

Бараа, үйлчилгээний бүлэг	2020 IX 2019 IX	2020 IX 2019 XII	2020 IX 2019 VIII
Ерөнхий индекс	101.8	100.9	99.4
Хүнсний бараа, ундаа, ус	103.9	102.4	96.3
Согтууруулах ундаа, тамхи	103.0	102.1	100.1
Хувцас, бөс, бараа, гутал	103.2	101.5	100.8
Орон сууц, ус, цахилгаан, түлш	101.4	101.0	100.0
Гэр ахуйн тавилга, бараа	105.0	104.0	100.5
Эм тариа, эмнэлэгийн үйлчилгээ	106.7	106.4	101.3
Тээвэр	90.1	89.3	99.2
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	100.0	100.0	100.0
Амралт, чөлөөлт цаг, соёлын бараа, үйлчилгээ	101.4	101.4	100.7
Боловсролын үйлчилгээ	100.0	100.0	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	100.7	100.7	100.9
Бусад бараа, үйлчилгээ	105.7	105.1	100.9

II.4 Хөдөө аж ахуйн зарим бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнэ

Мал аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийн үнийн судалгаагаар 2020 оны 9 сарын байдлаар ноолуур 40.0 мянга, адууны дэл 4.0 мянган төгрөг, адууны сүүл 5.7 мянган төгрөг, байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулвал ноолуур 20 хувиар буурсан байна. Арьс ширний нийлүүлэлт байхгүй байна.

II.5 Малын дундаж үнэ

Малын дундаж үнэ: 2020 оны 9 сарын байдлаар тэмээ 1027.0 мян.төг, адуу 955.0 мян.төг, үхэр 1179.0 мян.төг, хонь 171.0 мян.төг, ямаа 128.0 мян.төг болсон байна. Өмнөх сарын мэдээтэй харьцуулвал адуу 0.3 хувиар өссөн бол үхэр 0.7 хувиар, хонь 1.5, эр ямаа 3.3 хувиар буурсан үзүүлэлттэй байна.


**II.6 Аж үйлдвэр**

Аймгийн аж үйлдвэрийн газрууд 3962.1 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 5026.8 сая төгрөгийн бүтээгдэхүүний борлуулалт нийсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад үйлдвэрлэлт 10.0 хувиар, борлуулалт 8.3 хувиар тус тус буурсан байна. Бууралтын

шалтгаан нь аймгийн томоохон үйлдвэрлэлт хийгддэг гурилын үйлдвэрүүд, нүүрсний уурхайн үйл ажиллагаа эхлээгүй болно.

Зураг II.6.1

Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлт, борлуулалт /сая.төг/

**II.7 Хөдөө аж ахуй****Мал төллөлт, төл бойжилт**

Аймгийн хэмжээнд 2019 оны эцэст тоологдсон төллөх насны нийт 1651.4 мянган хээлтэгч малын 1248.6 мянга буюу 75.6 хувь нь 2020 оны эхний 9 сарын байдлаар төллөсөн байна. Гүүний 59.1 хувь, үнээний 70.4 хувь, ингэний 36.9 хувь, эм хонины 79.8 хувь, эм ямааны 72.7 хувь тус тус төллөсөн байна.

Гарсан төлийн 93.3 хувь буюу 1165.4 мянган төл бойжиж байна.


Зүй бусын хорогдол

Том малын зүй бусын хорогдол 2020 оны эхний 9 сарын байдлаар 133.9 мян.толгой болж, өмнөх оны мөн үеийнхээс 113.4 мян.толгой мал буюу 6.5 дахин өссөн байна. Нийт хорогдлыг малын төрлөөр авч үзвэл адуу 10.9 мян.толгой буюу 4 хувь, үхэр 10.0 мян.толгой буюу 3.6 хувь, хонь 80.2 мян.толгой буюу 4.2 хувь, ямаа 32.8 мян.толгой буюу 2.8 хувь нь оны эхний малаас тус тус хорогдоод байна. Нийт хорогдлын адуу 8.2 хувь, үхэр 7.5

хувь, ямаа 24.5 хувь, хонь 59.9 хувийг тус тус эзэлж байна. Хорогдлыг сумаар авч үзвэл Сайхан сум 39.7 хувийг, Баян-агт сум 28.4 хувийг тус тус эзэлж байгаа нь дийлэнх болж байна.

Зураг II.7.1

Зүй бусаар хорогдсон том малын эзлэх хувь



Зураг II.7.2

Зүй бусаар хорогдсон том мал, сумаар



II.8 Мал эмнэлгийн үйлчилгээ

2020 онд 1255.4 мян.толгой малд халдварт өвчнөөс сэргийлэх арга хэмжээний вакцин хийхээр төлөвлөгдснөөс 3-р улирлын байдлаар 1009.5 мян.толгой малд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцин хийж, 80.4 хувийн гүйцэтгэлтэй байна. Шимэгчтэх өвчнөөс сэргийлэх арга хэмжээний вакциныг 4957.3 мян.толгой малд хийхээр төлөвлөгдсөнөөс 2165.5 мян.толгой малд вакцин хийж, 43.8 хувийн гүйцэтгэлтэй байна.

Мал амьтдын шимэгчтэх өвчнөөр 309 голомтонд 60.3 мянган толгой мал өвчилж, 60.0 мянган толгой мал эдгэрч, 592 толгой мал үхсэн байна. Мал амьтдын халдварт өвчнөөр 74 голомтонд гарч, 715 толгой мал өвчилж, 120 толгой мал эдгэрч, 585 толгой мал үхэж, 10 толгой малыг устгасан байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулвал халдварт өвчны голомт 2.2 дахин, өвчилсэн малын тоо 2.1 дахин, Шимэгчтэх өвчны голомт 1.5 дахин, өвчилсэн малын тоо 3.4 дахин өссөн байна.

Ариутгал халдваргүйжүүлэлтийг 18 нэгжийн 644 м² түүхий эдийн талбай, 509 малын хашаа буюу 131.1 мянган м² талбай, 22 худаг уст цэгийн 1554 м² талбай, 51.3 мянган м² талбай голомтын бүс, 2.5 мянган м² устгалын цэгийн талбай, бэлчээрийн 7.6 мянган м² талбай, нийт 194.8 мянган м² талбайг халдваргүйжүүлсэн байна. Халдваргүйжүүлэлтэнд нийт 4671.5 мянган төгрөг зарцуулсан байна.

Хүснэгт II.8.1

Мал амьтны өвчин, хагас жилийн байдлаар

Үзүүлэлт	ХЭМЖИХ НЭГЖ	Халдварт өвчин	Шимэгчтэх өвчин
Голомтын тоо	ш	74	309
Өвчилсөн	толгой	715	60326
Эдгэрсэн	толгой	120	59990
Үхсэн	толгой	585	322
Устгасан	толгой	10	0

II.9 Газар тариалан

Аймгийн хэмжээнд нийт 48096.9 га талбайд тариалалт хийсэн байна. Үүнээс үр тариа 38336.5 га, төмс 552.2 га, хүнсний ногоо 188.2 га, тэжээлийн ургамал 4032, техникийн ургамал 4988 га-д тариалсан байна.

Тариалсан талбай өнгөрсөн онтой харьцуулахад нийт тариалсан талбай 5 хувиар буюу 2407.8 га-гаар буурсан үзүүлэлттэй байна.

Үүнээс: үр тариа 6.2 хувиар, техникийн ургамал 34.2 хувиар буурсан бол төмс 48 хувиар, хүнсний ногоо 42.2 хувиар, тэжээлийн ургамал 2.7 дахин өссөн байна.

2020 онд 696 өрх, 102 аж ахуй нэгж байгууллага буюу нийт 798 нэгж тариалалт эрхэлсэн байна.

Хүснэгт II.9.1

Тариалсан талбай, га

Бүтээгдэхүүний төрөл	Тариалсан талбай, га		
	2018 I-IX	2019 I-IX	2020 I-IX
Бүгд	48344.363	50504.674	48096.886
Үр тариа	42259.1	40913.7	38336.5
Төмс	323.88	373.111	552.186
Хүнсний ногоо	149.683	132.363	188.2
Тэжээлийн ургамал	910.5	1499.5	4032
Техникийн ургамал	4701.2	7586	4988

Хураасан ургац

Аймгийн хэмжээнд 2020 оны 9 сарын байдлаар нийт 15809 га талбайгаас 41676 тн ургац хураан авсан байна. Үүнээс үр тариа 23796.3, төмс 3381.8 тн, хүнсний ногоо 696.4 тн, тэжээлийн ургамал 13383.5 тн, техникийн ургамал 418 тн, 21500 тн бэлтгэсэн өвс, сүрэл 80 тн, хужир шүү 140 тн, гар тэжээл 448 тн хураан авсан байна.

Нийт тариалсан талбайн 37.6 хувийг хураасан байна.

Хүснэгт II.9.2

Бүтээгдэхүүний төрөл	Хураасан ургац, тн		
	2018 I-IX	2019 I-IX	2020 I-IX
Бүгд	29381.4	33942.53	41676
Үр тариа	22530	27515.1	23796.3
Төмс	3130.7	3807.9	3381.8
Хүнсний ногоо	709.7	489	696.4
Тэжээлийн ургамал	3011	2030.53	13383.5
Техникийн ургамал	-	100	418


Хүснэгт II.9.3

Бүтээгдэхүүний төрөл	Хураасан ургац, тн		
	2018 I-IX	2019 I-IX	2020 I-IX
Бэлтгэсэн өвс	28859	29110	21500
Сүрэл	5	122	80
Хужир шүү	931.4	115.7	140
Гар тэжээл	318.9	254	448
Эмийн ургамал	0.15	-	0.03




II.10 2020 оны 10 дугаар сарын цаг агаарын урьдчилсан мэдээ


Бүс нутаг	I-р 10 хоног			II-р 10 хоног			III-р 10 хоног		
	Эхэн	Дунд	Эцэс	Эхэн	Дунд	Эцэс	Эхэн	Дунд	Эцэс
Агаарын температур: Энэ сард агаарын дундаж температур нь нийт нутгаар ОЖД-ийн орчим байх төлөвтэй.									
Ихэнх нутгаар	Шөнө: 0-5 Өдөр: -1+4	Шөнө: -5-10 Өдөр: +4+9	Шөнө: -6-11 Өдөр: -1+6	Шөнө: -3-8 Өдөр: +4+9	Шөнө: -13-18 Өдөр: 2+3	Шөнө: -10-15 Өдөр: +2+7			
Хур тунадас: Энэ сард ихэнх нутгаар ОЖД-ийн орчим орох төлөвтэй.									
Хур тунадас	Ихэнх нутгаар хур тунадас, улаараа нойтон цаг орно	Хур тунадас ороогүй	Ихэнх нутгаар хур тунадас, улаараа нойтон цаг орно	Хур тунадас ороогүй	Ихэнх нутгаар хур тунадас, улаараа нойтон цаг орно	Зарим газраар хур тунадас, улаараа нойтон цаг орно	Хур тунадас ороогүй		
Салхи	Ихэнх хугацаанд 6-11 м/с, нэг, хоёр, гуравдугаар арав хоногийн эхээр зарим үед 15-17 м/с хүртэл ширүүснэ.								



Агаарын температур



Хур тунадас



[Улаан – агаарын хамгийн их температур, хөх – агаарын хамгийн бага температур, ногоон – хур тунадас]


Дэлхийн цаг уурын байгууллагаас тогтоосноор олон жилийн дундаж (ОЖД) утга гэдэг нь 1981-2010 оны хоорондох тухайн цаг уурын хэмжигдэхүүний дундаж утгыг авч үздэг.

Цаг агаарын үзэгдэл нутгийн 30 хувиас хэтрэхгүйгээр зурвас газраар ажиглагдах тохиолдолд "зарим газраар", 30-70 хувьд "ихэнх нутгаар", 70 хувиас дээш нутгийг хамрах тохиолдолд "нийт нутгаар" гэсэн нэр томъёо хэрэглэдэг.

Хүснэгт I.I.1 Хүн ам, өрх

Сум	Хүн ам				2019 2018	Эрэгтэй				2019 2018	Эмэгтэй				2019 2018
	2016	2017	2018	2019*		2016	2017	2018	2019*		2016	2017	2018	2019*	
Баян-Агт	3119	3218	3251	3212	98.8	1583	1632	1645	1631	99.1	1536	1632	1604	1581	98.6
Баяннуур	1818	1861	1827	1756	96.1	969	998	976	932	95.5	849	998	850	824	96.9
Бугат	2241	2277	2198	2125	96.7	1187	1208	1157	1123	97.1	1054	1208	1041	1002	96.3
Булган	12512	12616	12582	12310	97.8	6104	6125	6150	6016	97.8	6408	6125	6422	6294	98.0
Бүрэгхангай	2832	2888	2872	2761	96.1	1459	1482	1469	1430	97.3	1373	1482	1399	1331	95.1
Гурванбулаг	3176	3219	3289	3168	96.3	1644	1660	1686	1614	95.7	1532	1660	1601	1554	97.1
Дашинчилэн	2941	3037	3008	3006	99.9	1492	1540	1523	1512	99.3	1449	1540	1482	1494	100.8
Могод	2701	2729	2711	2643	97.5	1383	1394	1392	1364	98.0	1318	1394	1318	1279	97.0
Орхон	3584	3595	3477	3363	96.7	1911	1913	1856	1792	96.6	1673	1913	1615	1571	97.3
Рашаант	3165	3215	3253	3157	97.0	1602	1618	1641	1591	97.0	1563	1618	1607	1566	97.4
Сайхан	3648	3662	3561	3501	98.3	1854	1871	1799	1782	99.1	1794	1871	1757	1719	97.8
Сэлэнгэ	3306	3332	3343	3242	97.0	1723	1733	1743	1719	98.6	1583	1733	1598	1523	95.3
Тэшиг	3504	3563	3560	3549	99.7	1782	1820	1809	1812	100.2	1722	1820	1751	1737	99.2
Хангал	4611	4705	4660	4418	94.8	2302	2343	2331	2204	94.6	2309	2343	2327	2214	95.1
Хишиг-Өндөр	3156	3158	3152	3013	95.6	1595	1592	1578	1522	96.5	1561	1592	1570	1491	95.0
Хутаг-Өндөр	4835	4952	5050	4985	98.7	2487	2546	2573	2560	99.5	2348	2546	2467	2425	98.3
Нийт хүн ам	61149	62027	61794	60209	97.4	31077	31475	31328	30604	97.7	30072	31475	30409	29605	97.4

Зураг I.I.1 Хүн амын нас хүйсийн суварга 2019 он



I.2 ХӨДӨЛМӨР

Хүснэгт I.2.1 Хөдөлмөр

Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар

Үзүүлэлт	2019 IX		2020 IX		2020 IX % 2019 IX	
	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй
Ажил хайгч иргэн /сарын эцэст/	736	384	2026	908	275.3	236.5
Бүртгэлтэй ажилгүй иргэн /сарын эцэст/	366	212	1140	561	311.5	264.6
Ажилд зуучилсан иргэн /эдийн засгийн салбараар/	654	317	649	272	99.2	85.8
ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан, агнуур	129	53	177	73	137.2	137.7
Уул уурхай олборлолт	58	16	42	11	72.4	
Боловсруулах үйлдвэр	20	11	5	2	25.0	18.2
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	3	0	3		100.0	
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ	11	9	11	9	100.0	100.0
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа, холбоо мэдээлэл	1	0	10	1		
Зочид буудал, байр, сууц болон нитийн хоолны үйлчилгээ	7	5	2	2		
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	30	12	20	8	66.7	66.7
Боловсрол	44	39	16	11	36.4	28.2
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	31	28	13	10	41.9	35.7
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа						
Бусад	320	144	350	145	109.4	100.7
Бүртгэлтэй ажилгүй иргэн (насны бүлгээр)	366	212	1140	561	311.5	264.6
15-24	71	39	124	67	174.6	171.8
25-34	140	83	425	222	303.6	267.5
35-44	90	55	294	141	326.7	256.4
45-54	52	31	225	105	432.7	338.7
55-59	10	2	56	17	560.0	850.0
60+	3	2	16	9	533.3	450.0
Бүртгэлтэй ажилгүй иргэн (боловсролын түвшнээр)	366	212	1140	561	311.5	264.6
Магистр, доктор	0	0	4	3		
Дипломын болон бакалаврын дээд	75	53	204	134	272.0	252.8
Тусгай мэргэжлийн дунд	9	3	40	22	444.4	733.3
Техникийн болон мэргэжлийн	18	8	55	25	305.6	312.5
Бүрэн дунд	217	120	658	316	303.2	263.3
Суурь	34	22	130	47	382.4	213.6
Бага	9	4	38	10	422.2	250.0
Боловсролгүй	4	2	10	4	250.0	200.0

I.3 НИЙГМИЙН ХАЛАМЖ

Хүснэгт I.3.1 Нийгмийн халамжийн зарлага, хамрагдсан хүн

Үзүүлэлт	Хүний тоо		Олгосон тэтгэвэр, тэтгэмж, мян. төг		2020 IX 2019 IX
	2019 IX	2020 IX	2019 IX	2020 IX	
Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	9656	7497	3307496.7	1065946.7	32.2
Халамжийн тэтгэвэр	1047	1171	1482522.3	2,170,799.6	146.4
Нөхцөлт мөнгөн тэтгэмж	2506	1864	1038356.3	1137659.2	109.6
Үүнээс:					
Жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн	1081	241	157149.9	16930.9	10.8
Ахмад настныг асарч буй иргэний	911	1034	555442.9	675893.9	121.7
Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг	335	371	197590.7	238872.1	120.9
Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг	159	197	115412.3	192749.0	167.0
Бүтэн өнчин хүүхэд үрчлэн өсгөний	20	21	12760.5	13213.3	103.5
Нийгмийн халамжийн үйлчилгээ болон хөнгөлөлт	6103	2071	786618.1	269529.7	34.3
Ахмад настнуудад үзүүлсэн хөнгөлөлт тусламж	983	1626	287478.1	194721.2	67.7
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	184	292	62413.5	46478.5	74.5
Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ	0	153.0	0.0	28330.0	0.0
Хүнс тэжээл хөтөлбөр	4936	4522	462461.0	670640.0	145.0
Ахмад настнуудад үзүүлсэн хөнгөлөлт тусламж		16.1			
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлсэн хөнгөлөлт, тусламж		3.0			
Нийгмийн халамжийн хөнгөлөлт, нөхцөлт мөнгөн тусламж					
Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ		0			
Хүнс тэжээл хөтөлбөр		80.9			

Хүснэгт I.3.2 Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага

Үзүүлэлтүүд	2016 I-IX	2017 I-IX	2018 I-IX	2019 I-IX	2020 I-IX	2020 I-IX 2019 I-IX
Нийгмийн даатгалын сангийн орлого, сая.төг	8414.4	8831.9	7202	9177.4	10601.2	115.5
Үүнээс:						
Тэтгэврийн даатгалын сан	5225.5	5259.6	5996.8	7480.3	9111.6	121.8
Тэтгэмжийн даатгалын сан	581	654	673.1	839.1	833.9	99.4
Эрүүл мэндийн даатгалын сан	2064.3	2395.7				
ҮОМШӨ*-ний даатгалын сан	409.5	382.9	398.5	679.8	495.1	72.8
Ажилгүйдлийн даатгалын сан	134.1	139.7	133.6	178.2	160.4	90.0
Нийгмийн даатгалын сангийн зарлага, сая.төг	24058.4	25900.0	26846.0	30371.7	36380.8	119.8
Үүнээс:						
Тэтгэврийн даатгалын сан	20484.2	22072.0	25268.2	28627.8	34383.9	120.1
Тэтгэмжийн даатгалын сан	830.5	874.7	941.0	1033.4	1167.8	113.0
Эрүүл мэндийн даатгалын сан	2154.7	2361.1				
ҮОМШӨ*-ний даатгалын сан	361.6	322.2	387.2	519.4	479.9	92.4
Ажилгүйдлийн даатгалын сан	227.4	270.0	249.6	191.1	349.2	182.7

Хүснэгт 1.3.3 Нийгмийн даатгалын сангийн зарлага, хүнээр

Үзүүлэлтүүд	Хүний тоо		Нийгмийн даатгалын сангийн зарлага сая.төг		2020 I-IX 2019 I-IX
	2019 I- IX	2020 I-IX	2019 I-IX	2020 I-IX	
Тэтгэврийн даатгалын сан	9362	10244	28627.8	34383.9	120.1
Тэтгэмжийн даатгалын сан	1292	1386	1033.4	1167.8	113.0
ҮОМШӨ*-ний даатгалын сан	79	64	519.4	479.9	92.4
Ажилгүйдлийн даатгалын сан	131	191	191.1	349.2	182.7
Нийт дүн	10864	11885	30371.7	36380.8	119.8

1.4 ЭРҮҮЛ МЭНД

Хүснэгт 1.4.1 Аймгийн нэгдсэн эмнэлэгт төрсөн хүүхэд, нас баралт, төрлөөр, оноор

Үзүүлэлт	2017 IX	2018 IX	2019 IX	2020 IX	2020/2019
Амаржсан эхийн тоо	602	616	570	582	102.1
Амьд төрсөн хүүхэд	609	623	581	581	100.0
Эхийн эндэгдэл	-	-	-	-	-
Амьгүй төрөлт	0.0	4.0	3.0	5.0	-
Гэрийн төрөлт	4.0	2.0	3.0	3.0	-
Нэг хүртэл насандаа эндсэн хүүхэд	6.0	12	10	10.0	100.0
Перинаталь эндэгдэл	5.0	12	9	13.0	144.4
Амьд төрсөн 1000 хүүхэд тутмаас 1 хүртэл насанд эндсэн хүүхэд	9.9	19.3	17.2	17.2	-

Хүснэгт 1.4.2 Аймгийн хэмжээнд гарсан халдварт өвчин, өвчний төрлөөр, оноор

Үзүүлэлт	2017 IX	2018 IX	2019 IX	2020 IX	2020/2019
Нийт гарсан халдварт өвчин	352	295	314	426	135.7
Гэдэсний халдварт өвчин	5	36	29	33	113.8
Амьсгалын замын халдварт өвчин	194	105	112	95	84.8
Байгалын голомтот халдварт өвчин	14	8	4.0	3.0	75.0
Бэлэгсийн замаар дамжих халдварт өвчин	118	127	139	260	187.1
Арьсны халдварт өвчин	21	19	31	36	116.1

I.5 ГЭМТ ХЭРЭГ

Хүснэгт I.5.1 Бүртгээгдсэн гэмт хэрэг, сумдаар

Сум	2016 I-IX	2017 I-IX	2018 I-IX	2019 I-IX	2020 I-IX	$\frac{2020 \text{ I-IX}}{2019 \text{ I-IX}} \%$
Булган	57	70	57	59	65	110.2
Баян-Агт	8	7	10	14	15	107.1
Баяннуур	5	8	6	9	9	100.0
Бугат	12	24	19	30	31	103.3
Бүрэгхангай	10	14	17	20	41	205.0
Гурванбулаг	7	9	8	18	12	66.7
Дашинчилэн	9	9	4	11	11	100.0
Могод	8	7	6	10	6	60.0
Орхон	21	36	15	64	40	62.5
Рашаант	5	12	12	16	16	100.0
Сайхан	11	12	11	14	20	142.9
Сэлэнгэ	4	18	9	21	20	95.2
Тэшиг	7	10	8	9	6	66.7
Хангал	4	19	9	9	33	366.7
Хишиг-Өндөр	7	13	7	28	14	50.0
Хутаг-Өндөр	18	15	24	31	27	87.1
Хялганат	1	8	4	4	12	300.0
Бүгд	194	291	226	367	378	103.0

Хүснэгт I.5.2 Хулгайн гэмт хэрэг, сумдаар

Сум	2016 I-IX	2017 I-IX	2018 I-IX	2019 I-IX	2020 I-IX	$\frac{2020 \text{ I-IX}}{2019 \text{ I-IX}} \%$
Булган	19	30	23	19	14	73.7
Баян-Агт	2	3	7	12	3	25.0
Баяннуур	2	2	-	3	3	100.0
Бугат	6	8	2	8	5	62.5
Бүрэгхангай	4	2	6	10	11	110
Гурванбулаг	1	3	2	11	5	45.5
Дашинчилэн	4	2	2	6	7	116.7
Могод	5	2	3	5	1	20
Орхон	11	16	5	45	16	35.6

Рашаант	2	3	5	7	6	85.7
Сайхан	3	8	6	5	14	280.0
Сэлэнгэ	1	6	2	5	7	140.0
Тэшиг	1	1	2	1		0.0
Хангал	-	2	-	3	6	200.0
Хишиг-Өндөр	3	4	1	16	1	6.3
Хутаг-Өндөр	4	6	6	11	4	36.4
Хялганат	-	1	-	-	3	-
Бүгд	68	99	72	167	106	63.5

Хүснэгт 1.5.3 Гэмт хэргийн улмаас учирсан хохирол

Үзүүлэлт	2016 I-IX	2017 I-IX	2018 I-IX	2019 I-IX	2020 I-IX
	сая.төгрөг				
Учирсан хохирол-Бүгд	543.2	1243.1	556.5	1215.5	900.4
Үүнээс:					
Нөхөн төлүүлсэн	386.6	307.2	191.9	453.3	819.4
Нөхөн төлүүлэлтийн хувь	31.1	55.2	34.5	37.3	37.3

Хүснэгт 1.5.4 Сумдын хэргийн илрүүлэлт

Сум	Бүртгэгдэх үедээ сэжигтэн этгээд нь тогтоогдоогүй хэрэг		Яллагдагчаар татаж ял сонгосон хэрэг		Хэргийн илрүүлэлтийн хувь	
	2019 он	2020 он	2019 он	2020 он	2019 он	2020 он
Булган	53	27	27	17	50.9	63.0
Баян-Агт	11	11	8	13	72.7	118.2
Баяннуур	7	4	4	1	57.1	25.0
Бугат	28	12	18	13	64.3	108.3
Бүрэгхангай	19	24	8	7	42.1	29.2

Гурванбулаг	15	7	10	2	66.7	28.6
Дашинчилэн	8	4	1	4	12.5	100.0
Могод	9	2	4	3	44.4	150.0
Орхон	59	16	27	11	45.8	68.8
Рашаант	10	7	3	5	30.0	71.4
Сайхан	10	14	3	2	30.0	14.3
Сэлэнгэ	18	8	10	7	55.6	87.5
Тэшиг	9	2	5	1	55.6	50.0
Хангал	7	9	3	14	42.9	155.6
Хишиг-Өндөр	24	3	14	5	58.3	166.7
Хутаг-Өндөр	27	13	9	6	33.3	46.2
Хялганат	1	3	1	5	100.0	166.7
Бүгд	315	166	155	116	49.2	69.9

II.2 ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА

Хүснэгт II.2.1 Бараа, ажил үйлчилгээний худалдан авалт, сая.төгрөг

№	Үйлчилгээний нэр төрөл	2019 он		2020 он			
		Тоо, хэмжээ	Батлагдсан төсөвт өртөг	Тоо, хэмжээ	Батлагдсан төсөл арга хэмжээ	Тоо, хэмжээ	Гэрээ байгуулсан нийт өртөг
1	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт	38	1800.9	2	79.0	2	77.7
2	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт	8	2421.2	7	685.2	7	685.2
3	Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалт	45	5431.2	39	4,352.7	39	4,144.6
4	Авто замын сангийн хөрөнгө оруулалт	1	30	-	-	-	-
5	Улсын төсөвийн хөрөнгө оруулалт	9	7530.9	20	8,483.4	20	6,931.9
6	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын хөрөнгө оруулалт	-	-	1	500.0	-	-
	Дүн	101	17214.2	69	14,100.3	9	11,839.4

Хүснэгт II.2.2 Бараа, ажил үйлчилгээ, гйүцэтгэл, сая.төгрөг

№	Үйлчилгээний нэр төрөл	2020 I-IX	
		Батлагдсан төсөвт өртөг	Гэрээний дүн
Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээ			
1	Соёлын төвийн барилгын засварын ажил /Гурванбулаг сум/	108.9	108.9
2	Цэцэрлэгийн барилгын их засвар /Бугат сум/	171.6	171.6
3	1-р сургуулийн биеийн тамирын талбайн тохижилт /Булган, Булган/	99.1	99.1
4	Сургуулийн дотуур байрны засвар /Баян-Агт сум/	100.0	100.0
5	Шинэ суурьшлийн бүсэд цахилгаан хангамж татах /Хишиг-Өндөр/	88.9	88.9
6	Сургуулийн барилгын Б блокийн засвар /Могод сум/	86.8	86.8
7	Эрүүл мэндийн төвийн уламжлалт, нөхөн сэргээх эмчилгээний тоног төхөөрөмж /Сайхан сум/	29.9	29.9
	Дүн	685.2	685.2
Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээ			
1	Шүдний эмчилгээний бор машин /Хишиг-Өндөр сум/	9.0	8.9
2	Багийн эмнэлгийн барилгын өргөтгөл /Хутаг-өндөр сум, Уньт баг/	70.0	66.6
	Дүн	79.0	75.5

Хүснэгт II.2.3 Бараа, ажил үйлчилгээ, гйүцэтгэл, сая.төгрөг

№	Үйлчилгээний нэр төрөл	2020 I-IX	
		Батлагдсан төсөвт өртөг	Гэрээний дүн
Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээ			
1	Спорт заалын барилга /Булган, Хангал сум/	445.0	438.8
2	Сургуулийн дотуур байрын гал тогооны барилгын их засвар /Булган, Могод сум/	78.0	77.9
3	Соёлын төвийн барилгын их засвар /Булган, Хишиг-Өндөр сум/	171.0	170.2
4	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 75 ор /Булган, Булган сум, 3 дугаар цэцэрлэг/	923.9	905
5	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 75 ор /Булган, Гурванбулаг сум/	1041.8	1003.9
6	Аймгийн Нэгдсэн эмнэлгийн ариутгалын тасгийн их засвар /Булган, Булган сум/	142.0	141.1

7	Эрүүл мэндийн төвийн барилгын их засвар /Булган, Баяннуур сум/	225.0	224.1
8	Эрүүл мэндийн төвийн барилгын их засвар /Булган, Дашинчилэн/	144.0	142.9
9	Үерийн далан /Булган, Сайхан сум/	431.0	50
10	Явган хүний замын гэрэлтүүлэг /Булган, Булган сум, 2 дугаар баг, "Б", "В" хэсгийн хооронд/	91.1	85
11	Сургуулийн барилгын засвар /Булган, Дашинчилэн сум/	50.0	48
12	Сургуулийн барилгын сантехникийн засвар/ Булган, Булган сум, 2 дугаар сургууль/	60.0	55.5
13	Сургуулийн барилгын засвар /Булган, Хишиг-Өндөр сум /	80.0	73.9
14	Засаг даргын Тамгын газрын барилга /Булган, Баян-Агт сум/	806.3	799.6
15	Шинэ хөдөө төсөл /Булган/	1429.3	430.4
16	Сумын эрүүл мэндийн төвийн их засвар /Булган, Гурванбулаг сум/	40.0	38.8
17	Сумын эрүүл мэндийн төвийн их засвар /Булган, Могод сум/	50.0	49.3
18	Хүүхдийн "Жаргалант" зуслангийн захиргаа, аж ахуй, гал тогооны барилга /Булган/	925.0	902.0
19	Ахмадын өргөөний барилга /Булган, Булган сум/	1300.0	1246.0
20	Булган сумын Хог хаягдлын төвлөрсөн цэг орчмын орчны бохирдлыг бууруулах	50.0	49.5
	Дүн	8483.4	6931.9

Хүснэгт II.2.4 Бараа, ажил үйлчилгээ, гүйцэтгэл, сая.төгрөг

№	Үйлчилгээний нэр төрөл	2020 I-IX	
		Батлагдсан төсөвт өртөг	Гэрээний дүн
Байгаль хамгаалах сан			
1	Ойн хортны тэмцлийн ажил /30000 га, Сэлэнгэ, Тэшиг, Хутаг-Өндөр, Орхон, Хангал, Бугат/	280.0	280.0
2	Ойжуулалт /300 га, Бугат, Сэлэнгэ, Могод, Хангал, Бүрэгхангай/	151.9	151.9
